

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 20,628,436.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,187,883 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

ХОЁР. 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) 2023 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажилласан.

Компанийн захиргаа 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн Мүүрь аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85.8 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах



зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 99,99-100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2023.02.17-ний № 01 тоот тогтоол)-ийн дагуу компанийн 2022 оны цэвэр ашгаас 1,187,883 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,291.4 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6,414.7 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 121,876.7 мянган төгрөг (Үүнээс 116,788.2 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 5,088.5 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 629 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байршуулж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9/59, 3/2223, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2023 оны 01/65 тоот бичгээр ирүүлсэн зөвлөмж, шаардлага, үүргийг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7-д заасан үүргийн дагуу Тахько (ХК) компанийн улирлын болон эхний хагас жилийн засаглалын үйл ажиллагааны тайлангуудыг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлж тайлагнасан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх

асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2023 оны их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Компани 2023 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-ийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанид холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2023 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангиллын нээлттэй компанийн шаардлагыг хангаж ажилласан.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани 2023 онд Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба, Анкор төв гэсэн бүтэцтэй, 23 орон тоотой ажиллахаар төлөвлөж, 16 орон тоо (Техник, үйлчилгээний албаны дарга, Сантехник, ХАБ-ын инженерийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр, Нягтлан бодогч, Анкор төвийн менежерийн ажлыг өөр ажилтанд давхар хариуцуулан ажиллуулсан)-оор ажилласан.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 31-ний 17 тоот тушаалаар Хөдөлмөрийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 84, 87, 88, 95 дугаар зүйлийн заалтыг үндэслэн компанийн цахилгаан, сантехникийн хэвийн тасралтгүй ажиллагааг хариуцан үүрэг гүйцэтгэж ажилладаг ажилтнуудын ажлын цаг, ээлжийн хуваарьт өөрчлөлт оруулж, ээлжийн нэг ажилтны нэг ээлжинд ажиллах цагийг 12 цагаар, нэг хоногийн өдрийн ээлжийг 09:00-21:00 цагаар, шөнийн ээлжийг 21:00-

09:00 цагаар, нэг ээлжинд нэг ажилтан ажиллуулахаар тус тус тогтоож, ээлжээр ажиллах ажилтны тоог 6 хүнтэй байхаар зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллаж байна.

Хөдөлмөрийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийн дагуу ээлжээр ажилласан ажилтнуудад шөнийн цагаар ажилласаны нэмэгдэл хөлс олгож, ажилтнуудыг шөнийн ба илүү цагаар ажилласан тохиолдолд нөхөж амраадаг болсон.

Компанийн 2022 оны санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Мүүрь аудит ХХК-аар олон улсын түвшний аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 58 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ шинээр байгуулж, бүх төрлийн даатгалын гэрээнүүдийн дагуу 2023 оны даатгалын хураамжинд 14,151.3 мянган төгрөг төлсөн.

Оёдлын үйлдвэр, компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настангуудыг цагаан сар, ахмадын баярыг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлж, ахмад настан Хөдөлмөрийн баатар 2, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан 1, гачигдал тохиолдсон ахмад настан 4, өндөр насны тэтгэвэрт гарсан 1 хүнд, нийтдээ 10,896 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмж, тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

Компанийн Анкор төвд 22 удаагийн 60 цагийн арга хэмжээний үйлчилгээ үзүүлж, 37,468.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэсийн албан хаагчдийн сургалтыг байгуулсан зохиолч нарын чуулга уулзалт, МҮХАҮТ-ийн дэргэдэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн уулзалт зэрэг байгууллагуудын 10 удаагийн үйл ажиллагааг үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн.

ИМ / М / 2023 / 38 / 12

Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал

Компани тайлангийн хугацаанд 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, тэдний ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан Цалингийн урамшуулал олгох журмын дагуу улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгож байна.

Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэг тасралтгүй боловсролын сургалтад суралцаж, анкор төвийн техникч Г.Сүхбаатар жолооны С ангиллын сургалт, семинарт оролцсон. Сургалтын зардалд 1,243.5 мянган төгрөг зарцуулсан.

Компанийн нийт ажиллагсад (ТУЗ-ын гишүүд орсон)-д 827,284.0 мянган төгрөгийн цалин, хөлс, урамшуулал олгож, цалингийн зардал компанийн 2023 онд нийт зардлын 29.2 хувь болсон байна.

Ажилтнуудын ажлыг Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн дагуу улирал тутам дүгнэж, 2023 онд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын зарим заалтыг бүрэн биелүүлсэн тул цалингийн урамшууллыг олгосон.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Захиргааны албаны дарга Ц.Доржготов Сантехникийн засварчин Г.Пүрэвдорж, Цахилгааны засварчин Л.Отгонбат нарыг өөрийнх нь хүсэлтээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалж, тус тусын үүрэгт ажлаас чөлөөлсөн. Ж.Ганхуягийг Техник, үйлчилгээний албаны даргын, М.Баянжаргалыг Сантехник, хөдөлмөрийн аюулгүй байдлын инженерийн ажил үүргийг хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгүүлж байна.

Компанийн 3 ажилтан (Г.Нямдорж, Б.Болдбаатар, Г. Сүхбаатар, У. Одхүү, Б.Бямбасүрэн)-д нийт 11,166.7 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгож ахуй амьдралд нь туслалцаа, дэмжлэг үзүүлсэн.

Ажилтнуудыг компанийн зардал (3,889.0 мянган төгрөг)-аар эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, үзлэг шинжилгээний оношийн дагуу мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгүүлж, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авч ажилласан.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Өнөөдөр Яармаг ТББ-ийн Өглөөний уншлага ТББ-ын Монгол орон даяар хэрэгжиж буй Өглөөний уншлага хөтөлбөр хувь хүний төлөвшил, нийгмийн асуудлыг маш энгийн байдлаар ном унших соёлоор дамжуулан ирээдүй хойч үедээ унших соёлыг түгээх зуршилыг бий болох төсөлд 20,000.0 мянган төгрөгийн, Нийгмийн хөгжил бидний ирээдүй ТББ, Зүрх сэтгэлийн боловсрол ТББ-ын хамтран хэрэгжүүлж буй сургуулийн өмнөх боловсролын 2-5 нас, бага боловсролын 6-12 хүртэлх насны хүүхдүүдийн сэтгэл

11/11/2023 10:47:11

хөдлөл, нийгэмшихүйн чадварыг хөгжүүлэх агуулга бүхий “Зүрх сэтгэлийн боловсрол” олгох хөтөлбөрийг санхүүжүүлж 40,000.0 мянган төгрөгийн хандив тусламж үзүүлсэн.

Мөн нийт ажилтнуудыг Улаанбаатар-Сэлэнгэ-Дархан-Улаанбаатар маршрутаар алжаал тайлах зуны аяллыг компанийн зардлаар зохион байгуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагын хүрээнд компанийн ажилтнууд ТЕДИ төвийн барилгын орчны талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, 500 ширхэг бутлаг ургамал, гацуур мод тарьж мод тарих хөдөлгөөнд оролцсон.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хуванцар хог хаягдлыг боловсруулж хуванцар түүхий эд гаргаж авах үйлдвэр байгуулах төслийн ажлын шаардлагатай зах зээлийн судалгааг “Момэйд Ви Эй Эй” ХХК-аар гүйцэтгүүлж хийлгэсэн.

Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 1,162.5 сая төгрөгийн зардлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн (Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 16-ны 12 дугаар тогтоол). Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн нарийвчилсан эдийн засаг, санхүүгийн тооцооллыг гаргах ажлын хэсэг байгуулж ажиллахаар шийдвэрлүүлсэн юм. Мөн ажлын хэсгийн гишүүд 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Япон улсруу албан томилолтоор явж SDGs полимер хольц үйлдвэрлэх дэвшилтэд технологитой танилцаж “Жи Жи Ай Хонг Конг” компанитай төслийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах гэрээ байгуулж урьдчилсан төлбөрийг төлөөд байна.

Түүнчлэн SDGs полимер хольц үйлдвэрлэх технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дээжийг 2 удаа Япон талын хамтран ажиллаж байгаа компанид хүргүүлж олон улсын лабораторид дээжийг шинжлүүлж сайжруулсан түүхий эдийг монголд авч ирэн цахилгааны хуванцар хоолой үйлдвэрлэдэг компаниар туршилтын бүтээгдэхүүн хийлгүүлээд байна. Мөн Монгол улсын Гаалийн төв лабораторид бүтээгдэхүүний түүхий эдийн шинжилгээ хийлгэсэн болно.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Их засварын ажил

- Гурвалжинд байрлах аж ахуйн агуулахад цахилгааны дэд өртөөг 250кВА байсныг 630 кВА болгон өргөтгөх ажлыг Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн олгосон зөвшөөрөл Техникийн нөхцлийн дагуу мэргэжлийн байгууллага болох Галт эрчим ХХК-тай АГ/2023-25 тоот Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 52,308.9 мянган төгрөгийн зардлаар гүйцэтгүүлэн хүлээн авсан.

Урсгал засварын ажил

Гурвалжин байрлах аж ахуйн агуулахын дулааны худгийн зөөх засварлах ажил, МА-II барилгын лифтний өрөөний засвар, агааржуулалтын фильтр солих мөн эрчим хүчний аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу тус баригын цонхнуудын засвар, Анкор төвийн барилгын агааржуулалтын засварын ажил, МА-III барилгын 1 ба 2 дугаар контурын ялтсан бойлерыг угааж шахалт хийх, Анкор төвийн барилгын цахилгааны ба гэрэлтүүлгийн, МА-I барилгын цахилгаан болон гэрэлтүүлгийн урсгал засвар, МА-II барилгын цахилгааны урсгал засвар, МА-III барилгын ХТП-477 дэд өртөөний төлөвлөгөөт урсгал засвар, МА-III барилгын цахилгааны ерөнхий тоолуур солих, баталгаажуулах, Оффис, МА-III, Анкор төв зэрэг 67,494.9 мянган төгрөг (үүнээс 46,808.8 мянган төгрөгийн барилгын, 12,120.3 мянган төгрөгийн цахилгааны, 8,565.8 мянган төгрөгийн сантехникийн)-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Хэвийн үйл ажиллагааг хангах бусад ажил

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор цахилгаан, дулааны эрчим хүч, усны хэрэглээг хангагч байгууллагуудтай гэрээ байгуулан хангаж ажилласан.

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 328,662.3 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Үүнд: цахилгаан 313,652.9, тарифийн зөрүү 5,009.5, үйлчилгээний үнэ 9,999.9 мянган төгрөгийг хэрэглэгчдэд хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 69,464.6 үйлчилгээний төлбөрт 2,941.3, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрт 961.8, усны төлбөрт 36,207.6 мянган төгрөгийн төлбөрүүдийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, өмч хөрөнгийн тооллого хийж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй.

Ажлын байр, ажиллах нөхцөл, аюулгүй байдал, санхүүгийн үйл ажиллагаа

Ажлын нөхцөлийг хангах зорилгоор 88,557.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (тавилга эд хогшил, компьютер зэрэг), 1,278.8 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч бэлтгэсэн.

Компанийн оффисын болон мэдээллийн системийн хэвийн сааталгүй ажиллагааг хангах зорилгоор Ай Ти аутсорсинг ХХК-тай гэрээгээр хамтран ажиллаж, интернет, компьютерын болон камерын төхөөрөмж, Wireless access point төхөөрөмж, Unifi controller серверийн өдөр тутмын үйлчилгээ хийлгэн ажиллаж байна. Майкрософт оффис 365, антивирусын программын хугацаа, лицензүүдийг сунгах, домайн нэрийн төлбөр хийх, windows сервер болон компьютерүүдийн үйлдлийн систем, оффисын прораммуудыг лиценз сунгах, сүлжээнд firewall төхөөрөмж суурилуулж, аж ахуйн агуулахад камер суурилуулан интернетэд холбож зайнаас хянах, тэдгээрийн найдвартай ажиллагааг хангах зэрэг сүлжээний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний ажлыг 16,673.2 мянган төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэсэн.

Тайлангийн хугацаанд ажлын байр, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг өдөр тутам хангаж ажилласнаар компанийн цахилгаан, өндөр хүчдэлийн шугам сүлжээ, хөдөлмөрийн ба галын аюулгүй ажиллагааны талаар зөрчил, дутагдал гараагүй болно.

Компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбогдсон санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон бусад төрийн байгууллагад тайлагнадаг статистик мэдээ, тайлангуудыг хуульд заасан хугацаанд гаргаж, илгээсэн (тушаасан) болно.

Компани 2023 онд улсын төсөвт 575,628.7 мянган төгрөг төлөхөөс 95.6 хувийг тайлангийн хугацаанд төлж барагдуулсан. Үүнд:

- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар 224,940.9 мянган төгрөг
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 24,126.5 мянган төгрөг
- ✓ Хувь хүний орлогын албан татвар 77,098.1 мянган төгрөг
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл 171,526.2 мянган төгрөг үүнд:
 - Даатгуулагч 71,172.9 мянган төгрөг
 - Ажил олгогч 100,353.2 мянган төгрөг
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн татвар 11,230.0 мянган төгрөг
- ✓ Газрын төлбөрт 32,951.1 мянган төгрөг

- ✓ Авто тээврийн өөрөө явах хэрэгслийн албан тавар, агаарын бохирдол болон зам ашигласны төлбөр 1,042.1 мянган төгрөг
- ✓ Ногдол ашгаас суутгасан татвар 6,146.8 мянган төгрөг
- ✓ Бусад татварт 1,554.0 бүгд 550,615.7 мянган төгрөг төлсөн.

Компани 2023 онд 3,581,015.3 мянган төгрөгийн орлоготой, 2,844,548.6 мянган төгрөгийн зарлагатай, 653,987.4 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2022 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 242,447.1 мянган төгрөг буюу 6.4 хувиар буурч, зардал 652,009.9 мянган төгрөг буюу 18.7 хувиар буурч, хуримтлагдсан ашиг 6,455,703.7 мянган төгрөг болж 9 хувиар өссөн байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ДАРГА



Э.ЧУЛУУНТОГТОХ

ХЯНАСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЭНХНАСАН